





**GENCO TOUR  
BUREAU JSC**

**2019**

**ЖЕНКО ТУР БЮРО  
ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**АГУУЛГА**

1. Компанийн танилцуулга
2. Удирдлагуудын талаарх мэдээлэл
3. Санхүүгийн мэдээлэл
4. Ноогдол ашгийн талаарх мэдээлэл
5. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл
6. Үйл ажиллагааны тайлан




# 1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

## Компанийн мэдээлэл

Компанийн оноосон нэр:	Женко Тур Бюро ХК
Үйл ажиллагааны чиглэл:	Дотоод, Гадаад аялал Дотоод, Гадаад шууд нислэг захиалга Бүх төрлийн тээврийн билет захиалга Зочид буудлын өрөө захиалга Гэр жуулчны бааз Уламжлалт баяр наадам зохион байгуулах Хурал, семинар зохион байгуулах
Эрхэм зорилго:	Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох.
Бидний уриа:	Тухлаг газрыг Та сонго Туулах замыг бид хөтөлье.
Үүсгэн байгуулагдсан огноо:	1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.
Компанийн удирдлага:	ТУЗ-ын дарга Данзан ДАЯНБИЛГҮҮН Гүйцэтгэх захирал Цэнд ЭНХСАЙХАН
Компанийн албан ёсны хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4, ЗИП код: 14251
Холбоо барих:	Утас: 7012 0202, 9322 9323 И-мэйл: info@genco-tour.mn Вэб хуудас: www.genco-tour.mn Фэйсбүүк: Genco.Tour.Bureau



# 1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

## Бүтэц зохион байгуулалт



# 1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

## Бүтээгдэхүүн үйлчилгээ



- Дотоод, Гадаадын шууд нислэг захиалга
- Бүх төрлийн тээврийн билет захиалга
- Зочид буудлын өрөө захиалга
- Гэр жуулчны бааз
- Уламжлалт баяр наадам зохион байгуулах
- Хурал, семинар зохион байгуулах

Женко тур бюро компани нь дотоодын өндөр зэрэглэлийн 10 гаруй зочид буудал, 20 гаруй ресторан, зоогийн газар, байгалийн үзэсгэлэнт газрууд бүхий 50 гаруй жуулчны бааз, бусад үзвэр үйлчилгээ, соёл амралтын томоохон газруудтай хамтран ажиллаж байна.

Мөн Ази, Европын орнуудтай, тэр дундаа, Япон, Сингапур, Солонгос, Хятад, Орос, Германы аялал жуулчлалын бизнесийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

## 2. КОМПАНИЙН УДИРДЛАГУУДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

#### Ердийн гишүүн



Дашцэрэн  
ДАВААСҮРЭН

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “Соёолж” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Данзан  
ДАЯНБИЛГҮҮН

- ТУЗ-н Дарга
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирал



Бүрэнмэнд  
ЛХАГВАДОРЖ

- ТУЗ-н Ердийн гишүүн
- Нэр дэвшүүлэх хорооны дарга, Аудитын хорооны гишүүн
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Тэргүүн дэд захирал



Баттулга  
НАМУУН

- ТУЗ-н Ердийн гишүүн



Халтмаа  
ЦЭНДБАЯР

- ТУЗ-н Ердийн гишүүн
- Цалин урамшууллын хорооны дарга
- “Баянгол ЗБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал



Цэнд  
ЭНХСАЙХАН

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “Женко Тур Бюро” ХК-ийн Гүйцэтгэх захирал

#### Хараат бус гишүүн



Балжинням  
АМАРСАНАА

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хорооны гишүүн
- “Хэрээг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Тэгшээ  
ОДНЯМ

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Аудитын хороо, нэр дэвшүүлэх хорооны гишүүн
- “Их Од Эндвенчэ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Баярсайхан  
АЛТАНСУВД

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Аудитын хорооны дарга, Цалин урамшууллын хорооны гишүүн
- “Файнаншил Про Аудит” ХХК Гүйцэтгэх захирал

### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Цэнд  
ЭНХСАЙХАН

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “Женко Тур Бюро” ХК-ийн Гүйцэтгэх захирал

#### Боловсрол:

1990-1996 онд Хими технологийн их сургуулийг шинжлэх ухаан инженерчлэлийн магистр,  
2007-2009 онд Виржина коллеж инженерчлэл автокад мэргэжлээр,  
2010-2012 онд Үндэсний Их сургууль San Diego CA инженер удирдлагын магистр.

#### Ажлын туршлага:

2007-2009 онд Advance auto parts corporation-д автокад,  
2009-2010 онд Carbone of America процессийн инженер,  
2013 оноос МТ корпораци-д захирал,  
2018 оноос “Женко Тур Бюро” ХК-ийн Гүйцэтгэх захирал

### 3. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт	Дүн (Мянган төгрөг)	
	2018 Q2	2019.Q2
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>2,567,231.9</b>	<b>2,242,203.7</b>
Борлуулалтын өртөг	2,514,226.1	1,913,211.8
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>53,005.8</b>	<b>328,922.3</b>
Хүүгийн орлого	109.0	867.8
Ерөнхий ба удирдлагын зардал	164,863.4	212,816.7
Бусад зардал	5,820.1	21,730.9
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,224.8	307.6
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-114,343.9</b>	<b>95,620.1</b>
Орлогын татварын зардал		11,878.0
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-114,343.9</b>	<b>83,743.0</b>

2019 Q2 - ийн борлуулалтын дүнг 2018 Q2 - ийн борлуулалтын дүнтэй харьцуулахад 12% бага байгаа хэдийч Борлуулалтын өртөг 85% (Борлуулалтын орлогод эзлэх хувь) хүртэл багасаж нийт ашиг 6.2 дахин нэмэгдсэн ба татварын дараах ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад (+) болж 83,7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### 4. НООГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ


Хугацаа	Нэгж хувьцаанд ноогдох ашиг	Тараасан хэлбэр
2008	1	ҮЦТХТ
2009	1,2	ҮЦТХТ
2010	1,25	ҮЦТХТ
2011	1,5	ҮЦТХТ
2012	1,6	ҮЦТХТ, ХК

Нийт 6,55

## 5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Энэхүү мэдээллийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас 2019 оны 04 дүгээр сарын 08-ний байдлаар авсан тархалтын судалгаанаас бэлтгэв.



НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 51893

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

### Тойм мэдээлэл



2019 оны эхний хагас жилийн байдлаар Азийн орнуудруу 335 аялагч аялуулж, дотооддоо 175 аялагч (Сингапур Малайзын шууд нислэгтэй аялал) хүлээн аван Монгол улсаар аялуулсан байна. Мөн 3-р сараас эхлэн цогцолборуудын гадна болон дотоод засвар, тохижилтын ажлуудыг эхлүүлсэн бөгөөд 4-р сараас хамтран ажилладаг байгууллагуудтай гэрээ шинэчлэн байгуулж цогцолборуудад тусгай хөтөлбөртэй үйл ажиллагаанууд зохион байгуулж эхллээ.

### Дэлгэрэнгүй мэдээлэл

Гадаад аялал  335  
Аялагч





## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дотоод аялал  175  
Аялагч



2019 оны эхний хагас жил нийт 13 аялалд 510 жуулчин аялууллаа. Үүнд:  
- Гадаад аялал: 12 улсруу 335 аялагч (Сингапур Малайзын шууд нислэгтэй аялал орсон),  
- Дотоод аялал: Монгол орны үзэсгэлэнт газруудаар 175 аялагчдын тус тус амжилттай аялуулаад байна.

### Арга хэмжээ

🌀 Шинийн нэгний нар харах ёслол.

2019.02.05



Жил бүр уламжлал болгон зохион байгуулладаг “Шинийн нэгний нарыг угтах ёслол” арга хэмжээ Чингис Хааны Морьт Хөшөөн цогцолборт зохион байгуулан нийт 34 зочид ирж тус арга хэмжээнд оролцлоо. Энэ үед ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулагдаж хурсан олон Сар шинийн эхний нарыг хийморь өөд угтан авлаа.

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Ай Ти Эм Монголиа - 2019” Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн.

2019.03.29-31



Жил бүр зохион байгуулагддаг ITM 2019 Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож 53 байгууллагатай хамтран ажиллах гэрээ үйлдэн хамтын ажиллагаагаа өргөжүүллээ.

Хүүхдийн боловсролд зориулсан “Бид хамтдаа” хөтөлбөр эхлэв.

2019.04.01



Жил бүр зохион байгуулагддаг ерөнхий боловсролын сурагчдад зориулсан, тэдэнд Монгол түүх соёл, аж ахуйг танин мэдүүлэх зорилготой “Бид хамтдаа” хөтөлбөрийг шинэчлэн эхлүүлж тус хөтөлбөрт 2019 оны эхний хагас жилийн байдлаар 14 сургуулийн 462 хүүхдийг хамруулсан байна.

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- 2 удаагийн хуримын үзэсгэлэнд оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулав.

2019.04.14 (One event hall)

2019.05.18 (Crocus event hall)



Хурим хийхээр төлөвлөж буй хосуудад зориулан 2 удаа зохион байгуулагдсан “Хурим 2019” үзэсгэлэнд Лимузин Хаммер автомашин, Алтан ташуур ресторан, Бал сарын аяллуудыг сурталчлан оролцлоо.

- “Холливүүд Монголиа” төслийн багийн хүлээн авалтыг XIII зуун цогцолборт зохион байгуулав.

2019.05.06



Монголд анх удаа зохион байгуулагдсан Монголын кино урлагийг хөгжүүлэх зорилготой “Холливүүд Монголиа” төслийг дэмжин ажиллаж Холливүүдийн зочид, зохион байгуулагчдын багаас бүрдсэн 70 хүнийг 13-р зуун цогцолборт хүлээн авч Монголын каскадёрын холбоо, үндэсний хөгжмийн уран бүтээлчидтэй хамтран “Бэсрэг наадам” амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээгээр Холливүүдын жүжигчин Руди Ионгблүүд, “Game of Thrones” киноны найруулагч Дэвид Петрарка, жүжигчдийн дасгалжуулагч Ивана Чаббак, Америкийн зураглаачдын нийгэмлэгийн ерөнхийлөгч Кеес Ван Оострум, продюсер Тим Коддингтон зэрэг Холливүүдын “А” зэрэглэлийн 16 зочид хүрэлцэн ирсэн бөгөөд гадаад болон дотоодын кино уран бүтээлчдэд зураг авалт хийх орчин, боломжуудыг танилцуулж харилцаа холбоо тогтоолоо.

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- “Чингисийн үрсийн баяр” хүүхдийн баярын арга хэмжээг Чингис Хааны Морьт хөшөөний гадна талбайд зохион байгуулав.

2019.06.01



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу хүүхдийн баяраар Чингис Хааны Морьт Хөшөөний гадна талбайд 1200 орчим хүүхдүүд цугларч “Чингисийн үрсийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний үеэр уран бүтээлчид үлгэрийн баатруудын хамтарсан урлагийн тоглолтууд болж, “Чингис Хааны Хөшөөг хэн сайн зурах вэ?” гар зургийн уралдаан зохион байгуулагдлаа.

- “Талын салхи 2019” арга хэмжээг хамтран зохион байгуулав.

2019.06.08



Олон улсын мотоциклчдын арга хэмжээ болох “Талын салхи 2019” наадмыг “Монголын чопперчин ахан дүүс” ТББ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулж Чингис Хааны Морьт Хөшөө цогцолборт 800 мотоциклтой цуваатай 1000 орчим зочдыг хүлээн авлаа.

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- “Хүннү Мюзик Фестивал 2019” хөгжмийн наадмыг Чингис Хааны Морьт хөшөөнд хамтран зохион байгуулав.

2019.06.29



“Хүннү Мюзик Фестивал 2019” хөгжмийн наадмыг OnAid маркетингийн агентлагтай хамтран Чингис Хааны Морьт Хөшөөний гадна талбайд зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр 3000 орчим зочид цугларсан бөгөөд үндсэн хөтөлбөрөөс гадна зочдод зориулж үзвэр үйлчилгээ, гэр баазыг онцгой урамшуулалтай нөхцөөр олгож хамтран ажиллаа.

### Тохижилт, засвар

- Чингис Хааны Морьт Хөшөө цогцолбор

2019 онд гадна тохижилт дээр цэцэрлэгжүүлэлт болон шатны засварын ажил дээр голлон анхаарч ажиллаж байгаа бөгөөд цэцэрлэгжүүлэлтийн ажил төлөвлөсөн хугацаандаа дуусч шатны засварын ажилууд хийгдэж байна.

- 13-р зуун цогцолбор

13-р зуун цогцолбор нь газар нутаг, цаг агаарын онцлогоос шалтгаалан улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг ба өвлийн улирал буюу 11 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01 хүртэл Хааны өргөө, Бөөгийн отог, 05 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 01 хүртэл бүх отгуудаа нээн зочдод үйлчилгээ үзүүлдэг.

Шинэчлэн засварлах ажлын хүрээнд:

- Баазын бүх гэрийн дотор болон гадна засвар болон шаардлагатай хэсгүүдийг шинэчлэж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.
- Боловсон нойл, душийг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.
- Гал тогооны дээврийг засварлах ажлын тооцоо гарган материалын татан авалт хийн засварын ажлыг эхлүүлээд байна.
- Малын тооллого хийж сүргийн бүтэц, ашиг шим авах, тоо толгойг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажилласан бөгөөд цаашид төлөвлөгөөний дагуу ажлуудаа зохион байгуулж байна.

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Дотоод сургалт

- Үйлчилгээний ажилтнуудад зориулсан мөн ажлын байран дахь хоол зүйл зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал зуршил сэдэвтэй 2 удаагийн сургалтыг шаардлагатай ажилтнуудын дунд зохион байгуулав.



*Тухлах газрыг та сонго  
Тухлах замыг бид хөтөлье*

### Холбоо барих



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал,  
Оффис-4, Зип код: 14251

7012 0202

info@genco-tour.mn

